

2017 оны 3. сарын 16. өдөр

Дугаар № 17/04

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжист хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.2, 64.4 дэх хэсэг, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4 дэх хэсэг, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дах заалт, Санхүүгийн зохицуулах хорооны хорооны 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам” болон “МИК Холдинг” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2 дах заалт, “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 16/06 тоот тогтоолоор батлагдсан “МИК Холдинг Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай журам” -ыг тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсгийн дагуу “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт “МИК ОССК” ХХК-ийн байранд зохион байгуулж, хуралдуулахаар зарласугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр шийдвэрлэсүгэй.
Үүнд:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 2. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
 3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;
 4. Компанийн ТУЗ-ийн зардлын 2017 оны төсвийн төслийг батлах.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2017 оны 4 дүгээр сарын сарын 05-ны өдрөөр тогтоосугай.
 4. Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны хорооны 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам” -ын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийн хяналтыг хуудсыг Хавсралт 1-ийн дагуу баталж, 2017 оны 3 дугаар сарын 17-ний өдөрт багтаан Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-д хүргүүлсүгэй.
 5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг Хавсралт 2-ын дагуу баталж, 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдөр өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлэг түгээдэг радио, телевизээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, уг зарыг 2017 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
 6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 3-ын дагуу баталж, энэхүү баримт бичгийг 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигч банкуудад албан шуудангаар, бусад хувьцаа эзэмшигчид тэдгээрт үйлчилж буй брокер дилерийн компанийд хэвлэмэл

болон цахим хэлбэрээр хүргүүлэх замаар танилцах бололцоог хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн дарга Мягмар овогтой Мөнхбаатарыг томилсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга	Ж.Онон, ТУЗ-ийн ажлын албаны дарга
Гишүүн	Ц.Алтантуяа, ТЗК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Гишүүн	Ч.Цэрэндулам, ТЗК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дарга, гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга	С.Амарсайхан, “МИК ОССК” ХХК-ийн Эрсдэлийн удирдлагын газрын захирал
Гишүүн	Э.Маргад-Эрдэнэ, “МИК ОССК” ХХК-ийн Ипотекийн хөрөнгийн үнэлгээний хэлтсийн захирал
Гишүүн	Ж.Элбэгсайхан, “МИК ОССК” ХХК-ийн Ахлах хуульч, нууцын мэргэжилтэн
Гишүүн	Б.Болортuyaа, “МИК ОССК” ХХК-ийн эрх зүйч, гэрээний хуульч
Гишүүн	Р.Сэргжмядаг, “МИК ОССК” ХХК-ийн эрх зүйч, гэрээний хууль
Гишүүн	Т.Одгариg, “МИК ОССК” ХХК-ийн Хуульч
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авч, түүнийг үндэслэн хурлын тогтоолыг гаргахыг хурлын даргад үүрэг болгосугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг Хавсралт 4-ийн дагуу, санал авах хуудсыг Хавсралт 5, 6-ын дагуу тус тус баталсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсыг брокер дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт санал авах ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгож, тэдгээр саналын хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 17:00 цагаар тасалбар болгон тогтоосугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахтай холбогдон гарах зардлыг төсвийг баталж санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Д.Гантөгс)-д зөвшөөрсүгэй.
14. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн ажлын алба (Ж.Онон)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.МОНХБААТАР

“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах засгийн

2017 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 17/07 тоот

тогтоолын Хавсралт №1



**“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН МЭДЭГДЭЛ**

Компанийн нэр:	“МИК Холдинг” ХК
Хаяг, утас:	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо 13 хороолол, Энхтайвны өргөн чөлөө-19, 10-р давхар Утас: 328267
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт “МИК ОССК” ХХК-ийн байранд (Сүхбаатар дүүрэг, 1-р хороо 13 хороолол, Энхтайвны өргөн чөлөө-19, 10-р давхар, 1007 тоот)
Хурлын төрөл	Ээлжит
Хурал зарлагч	ТУЗ
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2017 оны 3 дугаар сарын 16-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2017 оны 3 дугаар сарын 21-ны өдөр
Бүртгэх өдөр:	2017 оны 04 дугаар сарын 05-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанийд хүргүүлэх огноо:	2017 оны 3 дугаар сарын 27-ны өдөр
Хүргүүлсэн огноо:	
Хурлын даргын нэр	М.Мөнхбаатар
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Комиссын дарга: С.Амарсайхан, “МИК ОССК” ХХК-ийн Эрсдэлийн удирдлагын газрын захирал; Гишүүн: Э.Маргад-Эрдэнэ, “МИК ОССК” ХХК-ийн Ипотекийн хөрөнгийн үнэлгээний хэлтсийн захирал; Гишүүн: Ж.Элбэгсайхан, “МИК ОССК” ХХК-ийн Ахлах хуульч, нууцын мэргжилтэн; Гишүүн: Б.Болортуяа, “МИК ОССК” ХХК-ийн эрх зүйч, гэрээний хуульч; Гишүүн: Р.Сэргжмядаг, “МИК ОССК” ХХК-ийн эрх зүйч, гэрээний хуульч; Гишүүн: Т.Одгариg, “МИК ОССК” ХХК-ийн Хуульч.
Баримт, бичгийн жагсаалт /Хавсралтаар/:	
Баримт, бичгийн хуудсын тоо:	

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

..... /...../
2017 оны ____ дугаар сарын ____ -ний өдөр

“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн үйлчилгээнд
2017 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 17/07 тоот

тогтоолын Хавсралт №2

МИК
ХОЛДИНГ

ХК

038-ш.5221978

УЛААНБААТАР ХОТ

**“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ЗАР**



Компанийн нэр:

“МИК Холдинг” ХК

Хаяг:

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо 13 хороолол, Энхтайвны өргөн чөлөө-19, 10-р давхар

Хурал хуралдах огноо, цаг, газар:

2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт “МИК ОССК” ХХК-ийн
байранд (Сүхбаатар дүүрэг, 1-р хороо 13 хороолол, Энхтайвны өргөн чөлөө-19,
10-р давхар, 1007 тоот)

**Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн иэрсийн
жагсаалт гаргах Бүртгэлийн өдөр:**

2017 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТҮЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТҮЗ-ийн шийдвэрийг танилцуулах
3. ТҮЗ-ийн гишүүдийг сонгох
4. Компанийн ТҮЗ-ийн зардлын 2017 оны төсвийн төслийг батлах

**Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт
бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:**

- Хувьцаа эзэмшигчид 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хооронд үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хандан эсвэл компанийн байранд ирж хурал зохион байгуулах комиссын даргад мэдэгдэн хурлын баримт бичигтэй танилцаж болно.
- Хурал зохион байгуулах комисс нь Даваа-Баасан гаригт 09:00-13:00, 14:00-18:00 цагийн хооронд ажиллана.

Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн мэдээлэл:

Дарга Ж.Онон ТҮЗ-ийн ажлын албаны дарга

Email: onon@mik.m

Утас: 328267 ext 815

Гишүүн: Ц.Алтантуяа ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга

Email: altantuya@mik.mn

Утас: 328267 ext 828

Гишүүн: Ч.Цэрэндүлам ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга

Email: tserendulam@mik.m

Утас: 328267 ext 838

МИК Холдинг "ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2017 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 17/07 төрт

тогтоолын Хавсралт №3

ХОЛДИНГ
ХК

1116216038.5221978

УЛААНБААТАР ХОТ

**"МИК ХОЛДИНГ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ"**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
4. Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн анкет
5. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан
6. Компанийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын дүгнэлт
7. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
8. Компанийн ногдол хуваарилах тухай ТУЗ-ийн 17/05 тоот шийдвэр
9. Компанийн ТУЗ-ийн зардлын 2017 оны төсвийн төсөл
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас

МИК Холдинг "ХК-ийн Төлөөлөн үйлчилж
2017 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 17/07 төхөт

тогтоолын *Хасагалт №4*

ХОЛДИНГ

ХК

1116210038.5221978
УЛААНБААТАР ХОТ

**"МИК ХОЛДИНГ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДЭГ**

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцагч
1	Хурлын ирцийг бүртгэх	10:00-10:15	Тооллогын комисс
2	Хурлын ирцийг мэдээлэх	10:15-10:20	Тооллогын комисс
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлын дэгийг танилцуулах	10:20-10:30	Хурлын дарга
4	Хэлэлцэх асуудлуудын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина.	10:30-11:00	[•]
5	1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай 2. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах 3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай 4. Компанийн ТУЗ-ийн зардлын 2017 оны төсвийн төслийг батлах тухай	11:00-11:10	[•]
6	Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт	11:10-11:40	Тооллогын комисс
7	Саналын хуудсаар санал авч, нэгтгэн, санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах	11:40-11:55	[•]
8	Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн санал асуулгын дүнг тусган хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулж, төслийг батлуулах	11:55-12:00	Хурлын дарга

“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2017 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 17/07 тоот
тогтоолын Хавсралт №5



“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛДЫГ
САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:
Регистрийн дугаар:
Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг):
Үнэт цаасны дансны дугаар:
Бүртгэсэн УЦК-ийн нэр:
Брокерын овог нэр:

№	Хэлэлцэж, батлах асуудлууд	Тогтоолын төслийн дугаар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Татгалзсан бол таны өгөх санал
1	Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах	Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр № 1			
4	Компанийн ТУЗ-ийн зардлын 2017 оны төсвийн төслийг батлах	Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр № 3			

Хувьцаа эзэмшигч иргэн:

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгч:

Гарын үсэг:

Гарын үсэг:

Нэр:

Албан тушаал:

Брокерын гарын үсэг (тамга):

Саналын хуудас хүлээн авсан огноо, цаг:

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын Дарга:

Гишүүд:

Гишүүд:

Хүчингүйд тооцсон бол шалтгаан

.....

Саналын хуудасны арын нуурээс санал авах хуудас ашиглах санамжтай танилцана уу.

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ (+) тэмдэглэгээ хийнэ.
Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+), татгалзсан бол татгалзсан гэсэн нүдэнд (+) тэмдэг тавина.
2. Санал авах хуудасны эхний хэсгийг зуучлагч үнэт цаасны компанийн ажилтнууд бөглөн тэмдэг даран баталгаажуулж хувьцаа эзэмшигчдэд өгнө.
3. Засварласан, балласан болон залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хувьцаа эзэмшигчид нь 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн дотор хурлын материалтай танилцах бөгөөд хэрэв та хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол санал авах хуудсанд саналаа тэмдэглэн, үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа санал авах хуудсыг хүлээлгэн өгнө үү.
5. Хэрэв та саналаа итгэмжлэгдсэн этгээдээр төлөөлүүлэх бол итгэмжлэгдсэн этгээдийн мэдээллийг дор бичин итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ үү.

Таныг төлөөлөх итгэмжлэгдсэн этгээдийн мэдээлэл

Итгэмжлэгдсэн этгээдийн овог, нэр:

Регистрийн дугаар:

Таны эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг):

Гарын үсэг:



“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2017 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 17/07 тоот
тогтоолын Хавсралт №6

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛЫН ХУУДАС



1. Компанийн оноосон нэр: “МИК Холдинг” ХК
2. Хурал хуралдах газар, өдөр, цаг: 2017 оны 4-р сарын 28-ны Баасан гарagt, “МИК ОССК” ХХК-ийн байранд (Сүхбаатар дүүрэг 1-р хороо 13-р хороолол, Энхтайвны өргөн чөлөө-19, 10-р давхар, 1007 тоот), 10:00 цагт
3. Хувьцаа эзэмшигчийн нэр:
4. Эзэмшиж байгаа хувьцааны төрөл: Энгийн-□, Давуу -□
5. Эзэмшиж буй хувьцааны тоо: ширхэг.
6. Саналын хуудас хүлээн авсан огноо, цаг:.....
7. “МИК Холдинг” ХК-ийн ТҮЗ-ийн гишүүдийг сонгоход Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 367 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-ыг хэрэглэнэ.

Кумулятив аргын жишиг:

Хэрэв та 100 ширхэг хувьцаа эзэмшидэг бол таны өгөх нийт санал нь ТҮЗ-ийн гишүүдийн тоо 9-ийг таны эзэмшиж буй хувьцааны тоо 100-аар үргүүлжс нийт 900 саналын эрхтэй. Үүний 600 саналын эрхийг ТҮЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох б нэр дэвшигчид, 300 саналын эрхийг ТҮЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 нэр дэвшигчид 2 хувааж өгнө. Гэхдээ 600 саналын эрхээ ТҮЗ-ийн б ердийн гишүүнд нэр дэвшигчид хувааж өгч болохоос гадна, тодорхой нэг эсвэл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгч болно. Мөн 300 саналын эрхээ ТҮЗ-ийн 3 хараат бус гишүүнд нэр дэвшигчид хувааж өгч болохоос гадна, тодорхой нэг эсвэл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгч болно. Харин таны нийт саналын эрхийн тоо 900-с их буюу бага байж болохгүй.

№	Хэлэлцэх асуудал	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Саналын эрхийн тоо
1	“МИК Холдинг” ХК-ийн ТҮЗ-ийн ердийн гишүүдийг сонгох	ТҮЗ-ийн <i>ердийн гишүүнээр</i> Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Бямбажав овогтой Ганбатыг сонгосугай.	
		ТҮЗ-ийн <i>ердийн гишүүнээр</i> Хөгжлийн банкны Дэд захирал бөгөөд АПХУГазрын захирал Баяараа овогтой Чойжилжалбууг сонгосугай.	
		ТҮЗ-ийн <i>ердийн гишүүнээр</i> Голомт банкны Бизнес хөгжлийн газрын захирал Билэгбадрах овогтой Энхтуяаг сонгосугай.	
		ТҮЗ-ийн <i>ердийн гишүүнээр</i> Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал Лхагважав овогтой Гантөмөрийг сонгосугай.	
		ТҮЗ-ийн <i>ердийн гишүүнээр</i> Улаанбаатар хотын банкны Зөвлөх Мягмар овогтой Мөнхбаатарыг сонгосугай.	
		ТҮЗ-ийн <i>ердийн гишүүнээр</i> Хaan банкны Үйл ажиллагааны эрсдэл хариуцсан захирал Намсрай овогтой Оюунхандыг сонгосугай.	

		<p>ТУЗ-ийн <i>ердийн гишүүнээр</i> Төрийн банкны Гүйцэтгэх захирал Бадарч овогтой Цэндсүрэнг сонгосугай.</p> <p>ТУЗ-ийн <i>ердийн гишүүнээр</i> Хасбанкны Санхүү хариусан захирал Ганзориг овогтой Эрдэнэбаярыг сонгосугай.</p> <p>ТУЗ-ийн <i>ердийн гишүүнээр</i> Капитрон банкны Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч Чулуунхүү овогтой Энхбатыг сонгосугай.</p> <p>ТУЗ-ийн <i>ердийн гишүүнээр</i> Капитал банкны Эрсдэлийн удирдлагын газрын захирал Даваадорж овогтой Бадамчулууныг сонгосугай.</p>	
2	“МИК Холдинг” ХК-ийн ТУЗ- ийн хараат бус гишүүдийг сонгох	<p>ТУЗ-ийн <i>хараат бус гишүүнээр</i> Монгол улсын иргэн Дамбачүлтэм овогтой Байлыхүүг сонгосугай</p> <p>ТУЗ-ийн <i>хараат бус гишүүнээр</i> Монгол улсын иргэн Даваа овогтой Болдбаатарыг сонгосугай.</p> <p>ТУЗ-ийн <i>хараат бус гишүүнээр</i> Монгол улсын иргэн Энхбаяр овогтой Шижирийг сонгосугай.</p>	
3	Нийт саналын эрхийн тоо		

Жич: ТУЗ-ийн гишүүн сонгоход таны өгөх нийт саналын эрхийн тоо нь эзэмшиж буй хувьцааны тоог ТУЗ-ийн гишүүдийн тоо (9)-оор үржүүлсэнтэй тэнцэх бөгөөд энхүү тоо нь үүнээс их болон бага болох тохиолдолд таны санал хүчингүйд тооцогдохыг анхааралдаа авахыг хүсье.

Хувьцаа эзэмшигч иргэний нэр:	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр:
Гарын үсэг:.....	Албан тушаал:.....
Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг:.....	
Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг:	

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон:

1. Саналын хуудсыг хүчингүйд тооцсон тооллогын комиссын дарга.....
 - a. Комиссын гишүүд.....
 - b. Комиссын гишүүд.....
 - c. Комиссын гишүүд.....
 - d. Комиссын гишүүд.....
 - e. Комиссын гишүүд.....
 - f. Комиссын гишүүд.....
2. Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан:.....
.....
.....
.....